



Төслийн мэдээллийн Тайлан

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ) – д төсөл болон хөтөлбөрийн талаархи хураангуй мэдээлэл багтдаг. ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай байдаг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба бэлэн болсон үед нь нэмж оруулдаг. Хэрэгжихээр төлөвлөгдсөн төслийн талаарх мэдээлэл урьдчилсан байдлаар байгаа бөгөөд илтгэх шинж чанартай.

ТМТ-г боловсруулсан огноо –

ТМТ-г шинэчилсэн 2014оны 3-р сарын 25

Төслийн нэр Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл, хөтөлбөр (хуучнаар Нийгмийн эмзэг бүлгийн хүнс, тэжээл болон нийгмийн хамгааллыг хөгжүүлэх хөтөлбөр)

Улс Монгол Улс

Төсөл/Хөтөлбөрийн дугаар 42322-023

Төлөв Батлагдсан

Газар зүйн байрлал –

Аливаа нэг улсад зориулсан хөтөлбөр болон стратегийг бэлтгэх, төслийг санхүүжүүлэх болон аливаа томилгоог хийх, энэхүү баримт бичигт дурьдагдсан тодорхой газар нутаг болон орон нутгийн талаар ишлэл татахдаа Азийн Хөгжлийн Банк тухайн газар нутаг болон орон нутгийн хууль эрх зүйн болон бусад статусын талаар аливаа дүгнэлт өгөх зорилго агуулдаггүй болно.

Салбар/дэд салбарын ангилал Олон салбар
/ Олон салбар

Сэдвийн ангилал Чадавхи бэхжүүлэлт
Нийгмийн хөгжил

Жендерийн асуудлыг хэрэгжүүлэх байдал Жендерийн асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх

■ Санхүүжилт

Туслалцааны төрөл/ хэлбэр	Батламжийн дугаар	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлагдсан дүн (мянга)
Техник туслалцаа	8544	Техник туслалцааны тусгай сан	500
Loan	3086	Азийн хөгжлийн сан	20,000
–	–	Хамтран хэрэгжүүлэгчийн эх үүсвэр	3,270
–	–	–	–
НИЙТ			US\$ 23,770

■ Хамгааллын арга хэмжээний ангилал

Хамгааллын арга хэмжээний ангиллын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.adb.org/site/safeguards/safeguard-categories> цахим хуудаснаас үзнэ үү

Байгаль орчин	C
---------------	---

Албадан нүүлгэн шилжүүлэлт	C
----------------------------	---

Нутгийн уугуул иргэд	C
----------------------	---

■ Байгаль орчин, нийгмийн асуудлын хураангуй

Байгаль орчны асуудлууд

Хамгааллын арга хэмжээ авах шаардлагагүй

Албадан нүүлгэн шилжүүлэлт

Хамгааллын арга хэмжээ авах шаардлагагүй

Нутгийн уугуул иргэд

Хамгааллын арга хэмжээ авах шаардлагагүй

■ Оролцогч бүлгүүдийн харилцаа, оролцоо, санал авалт

Төслийн төлөвлөлтийн явцад

Сонирхлын гол бүлгүүдтэй зөвлөлдөх уулзалтууд хийгдсэн бөгөөд төслийг эцэслэн боловсруулж батлуулах явцад үргэлжлэн хийгдэнэ. Үүнд, НДЕГ, НХҮЕГ-ын ажилтнууд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Ниймийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын ажилтнууд болон удирдлагууд, төслийн одоогийн ажилтнууд болон НХҮЕГ-ын мэдээллийн технологийн хөгжилд дэмжлэг үзүүлж буй Дэлхийн банк зэрэг бусад этгээдүүдтэй хийх зорилтот бүлгүүдийн уулзалт хамрагдана. Төслийн бэлтгэл явцад ажилтнуудыг хамруулсан уулзалт зэрэг илүү өргөтгөсөн хүрээний зөвлөлдөх уулзалтууд хийгдэнэ.

Төслийн хэрэгжилтийн явцад

Төслийн хэрэгжилтийн явц дах сонирхлын бүлгүүдийн харилцаа, оролцоо, зөвлөлдөх уулзалтуудыг төслийн харилцааны хөтөлбөрт тусгах бөгөөд тус хөтөлбөрийг нийгмийн халамж, даатгалын үйлчилгээ нь цаг хугацаа, үр дүн, ил тод байдлын хувьд сонирхлын бүлгүүдийн (үүний дотор шууд үр ашиг хүртэгсэд) хүлээлтэд нийцэж буй эсэхийг хянах үүднээс жил жилээр хэрэгжүүлнэ.

■ Тодорхойлолт

Анхдагч хөтөлбөр (АХС-ийн 9 сая ам.доллар)-ийн хүрээнд хүнсийг талоноор олгох хөтөлбөрийг нийгмийн халамжийн тогтолцооны нэг хэсэг болгож боловсруулж, хэрэгжүүлсэн. Анхдагч төсөл (АХС-ийн 3 сая ам доллар)-өөр зорилтот бүлгийг тодорхойлох аргачлалыг сайжруулах болон нийгмийн хамгааллын шинэчлэлийн стратегийн хувилбаруудыг боловсруулсан. Нэмэлт санхүүжилтийн тусламжтайгаар нийгмийн хамгааллын чиглэлээр өнөөг хүртэл хийгдэж ирсэн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж анхдагч төслийн үйлчлэлийн хүрээг өргөтгөнө. Нийгмийн халамж үйлчилгээний тоо төрлийг оновчтой болгосноор нийгмийн халамжийн тогтолцооны нүсэр байдлыг багасгаж, үр нөлөөг дээшлүүлнэ. Орлогыг орлуулан тооцох аргаар ядуу өрхүүдийг сонгох аргачлалыг өргөжүүлэн бусад халамж үйлчилгээнд хэрэглэх боломж бүрдэнэ. Түүнчлэн нэмэлт санхүүжилтийн хүрээнд нийгмийн даатгалын үйлчилгээг боловсронгуй болгосноор анхдагч төслийн

хамрах хүрээг тэлэх юм. Үйл ажиллагааны зааварчилгаа ОМ Н5/ВР-ны 11 дүгээр бүлэгт заасан тэргүүлэх ач холбогдлын шалгууруудад нэмэлт санхүүжилт нийцэж байгаа болно. Үүнд: (i) төсөл сайн хэрэгжиж байгаа; (ii) нэмэлт санхүүжилт ашиглахад төслийн бэлэн байдал өндөр байгаа; (iii) үр дүнтэй, үр ашигтай, ил тод, хэрэглэгч төвтэй нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлж буй нь Монголын хувьд ихээхэн шинэлэг зүйл бөгөөд бусад салбаруудын хувьд жишиг болох боломжтой.

■ Төслийн үндэслэл, үндэсний/бүс нутгийн стратегитэй уялдах нь

Азийн хөгжлийн банк (АХБ) 2008 онд анхдагч хөтөлбөр, төслийг баталсан ба эдгээр нь зорилтод бүлэгт хүнсийг талоноор олгох, нийгмийн халамжийн тогтолцоог бэхжүүлэх замаар нийгмийн эмзэг бүлэг, ядуу өрхүүдийн хоол тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байсан. Нийгмийн халамжийг өөрчлөн шинэчлэх, нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх үйл явцыг үргэлжлүүлэх зорилгоор нэмэлт санхүүжилт олгох хүсэлтийг Засгийн газар АХБ-нд гаргасан. Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр, төслийг 2008 оны хүнс шатахууны хямралыг гатлан давах арга хэмжээ хэлбэрээр боловсруулсан бөгөөд нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх тодорхой алхам хэмээн үзсэн. Хөтөлбөрийн хүрээнд хүн амын хамгийн эмзэг бүлэгт зориулж хүнсийг талоноор олгох хөтөлбөрийг нийгмийн халамж үйлчилгээний төрөл болгон боловсруулж хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд ядуу эмзэг бүлгийг тодорхойлох шинэлэг аргыг тус улсад анх удаа нэвтрүүлэн хүнсий талон олгосон бөгөөд нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх багц стратегийг боловсруулсан. Монгол улсын эдийн засгийн хурдацтай өсөлт, албан секторт ажиллах хүчний хэмжээ үлэмж нэмэгдэх төлөв зэрэг нь нийгмийн даатгалын асуудалд илүүтэй анхаарах шаардлага, боломжийг бий болгож байна. Эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа хэдий ч ядуу, эмзэг иргэдийн тоо өндөр хэвээр байгаа нь нийгмийн халамжид тавих анхаарлыг сулруулахгүй байхыг шаардаж байна. 2012 оны 7-р сард батлагдсан шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт нийгмийн халамж, нийгмийн даатгалын салбарт шинэлэг бөгөөд илт тод санхүүгийн үйлчилгээ, мэдээлэл технологийн дэвшлийг нэвтрүүлэх тухай заасан. Энэ нь нийгмийн халамж үйлчилгээ, нийгмийн даатгалд иргэд сэтгэл дундуур байдаг суурь шалтгааныг арилгах, үйл ажиллагааг ил тод болгох тал дээр дорвитой өөрчлөлт хийх Засгийн газрын эрмэлзлийн илэрхийлэл юм. Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яам нь нийгмийн даатгалын таван санг захирах үүрэг бүхий Нийгмийн даатгалын ерөнхий газар болон нийгмийн халамж үйлчилгээний асуудлыг хариуцсан Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар гэсэн 2 харъяа агентлагтай. Эдгээр нь төвлөрлийг сайн сааруулж 21 аймаг, УБ хотын 9 дүүрэгт 30 орчим салбартай бөгөөд улмаар бүх 352 сум (засаг захиргааны нэгж)-д үйлчилгээгээ хүргэдэг. Тус яамны харъяа Хүүхдийн төлөө үндэсний төв болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх газар байдаг. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын ажилтнууд гар аргаар тайлан мэдээ гаргадаг ба, аймаг, сумд мэдээллийн сүлжээ ашиглах боломж хязгаарлагдмал, олон тооны мэдээллийн сан байдаг нь мэдээллийн удирдлага, боловсруулалт, тайлагналтыг хүндрүүлдэг зэрэг бэрхшээлтэй тулгардаг. Нийгмийн халамж. Нийгмийн халамжийн салбарт сүүлийн 10 жилийн хугацаанд АХБ-ны дэмжлэгтэйгээр дорвитой шинэтгэл хийгдсэн боловч нийгмийн халамжийн төсвийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн халамжүүдийг нэгтгэх замаар халамжийн үр нөлөөг нэмэгдүүлэх гэх зэрэг анхдагч асуудлуудыг шийдвэрлэх шаардлага хэвээр байсаар байна. Хэт олон төрлийн (жар гаруй) зорилтот бус, давхардсан хэлбэрийн халамж үйлчилгээ байгаа бөгөөд Нийгмийн халамж үйлчилгээний газарт нэгдсэн удирдлагатай чанарлаг мэдээллийн тогтолцоо байхгүйгээс халамж үйлчилгээ давхар олгогдох, анализ шинжилгээ хангалтгүй хийгдэх зэрэг алдаа дутагдал гарсаар байна. 2009 оноос хойш нийгмийн халамжийн салбарт гарсан ахиц дэвшлүүд дотор орлогыг орлуулан тооцох аргыг нэвтрүүлсэн, хавтгайруулан олгож байсан хэд хэдэн халамжийг цуцалсан, ядуусад тусгайлан зориулсан анхны халамж болох хүнсийг талоноор олгох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн, Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2012 онд батлагдсанаар шинэтгэлийн зорилтуудыг хуульчлан батлуулсан зэргийг нэрлэж болно. Нийгмийн халамж үйлчилгээг оновчтой болгохын тулд саад учруулж буй хүчин зүйлсийг арилгах, шинэчлэлийг тууштай хэрэгжүүлэх, олон нийттэй харилцах үр дүнтэй аргыг нэвтрүүлэх, чадварыг бэхжүүлэх шаардлагатай. Нийгмийн

даатгал. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт дор нийгмийн даатгалын 5 сан үйл ажиллагаа явуулдаг. Үүнд: (i) тэтгэврийн сан; (ii) ажилгүйдлийн сан; (ii) эрүүл мэндийн даатгалын сан; (iv) халамжийн сан (өвчлөл, амаржих, оршуулгын буцалтгүй тусламж); (v) үйлдвэрийг осол, мэргэжлийн өвчнөөс даатгах сан хамаарна. Хамрах хүрээний хувьд сан тус бүр ялгаатай хэдий ч бүгд засгийн газрын дэмжлэг хөрөнгөөр санхүүждэг. Эдгээрийн дотор тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын сангууд нь шимтгэлд суурилсан сангууд юм. Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамны зүгээс 2012 оны эцсийн байдлаар 850,00 хүнийг хамраад буй тэтгэврийн тогтолцоог шинэчлэх, шимтгэлд суурилсан дан шатлалт тогтолцооноос хувийн хэвшлийн оролцоог дэмжсэн олон шатлалт тогтолцоо руу шилжих ажлыг эхлүүлээд байна. Нийт хүн амын 98 хувьд хүрч үйлчилж буй эрүүл мэндийн даатгалын салбарт мөн засаглалыг бэхжүүлэх, бие даан удирдах боломжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх зэрэгт чиглэгдсэн шинэтгэлийн хөтөлбөр хэрэгжиж байна. Ажил эрхлэлт үндэсний хэмжээнд нэмэгдэж үүний хажуугаар тэгш бус байдал лавшрах хандлагатай байгаа энэ нөхцөлд нийгмийн даатгалын салбарын стратегийг шинэчлэн батлах, 2020 он хүртэлх хөгжлийн чиглэлийг тодорхойлох нь туйлын чухал болоод байна. НХҮЕГ, НДЕГ-ын мэдээллийн технологийн тогтолцоо. Уг хоёр байгууллагын системийг аваад үзвэл мэдээллийн технологийн процесс, програм хангамж, техник хангамж, сүлжээний хувьд нэлээд зөрүүтэй байна. Энэхүү хоёр байгууллагын мэдээллийн технологийн системийг хатуу зааглах нь үр ашигтай бус юм. Мэдээллийн технологийн хоёр орчин нэн нэгнээ харилцан нөхөх боломжтой бөгөөд технологийн шийдлүүдийг уялдаа холбоотойгоор хэрэгжүүлснээр үр өгөөжийг нэмэгдүүлэх, харилцан дэмжих, үүн дотор засвар үйлчилгээг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой. НДЕГ-т ашиглагдаж буй систем нь төрийн байгууллагад тавигддаг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагыг хангаж чадахааргүй хоцрогдмол систем юм. Нийгмийн халамжийн мэдээллийн технологийн системийг шинэчлэх шардлагатай бөгөөд энэ ажлыг Дэлхийн банкны техникийн туслалцааны төслөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. НХҮЕГ, НДЕГ аль аль байгууллагын хувьд процессийг ил тод бөгөөд оролцогч талын эрх ашигт нийцсэн болгох шаардлагатай. Хэрэглэгчийн серверийн програм хангамжийн одоо хэрэглэгдэж буй аппликейшн хэрэглээний програмыг вэб-д суурилсан интерфэйс болгон хөгжүүлснээр мэдээллийн технологийн процессийг илүү ил тод болгох боломжтой. Тайлагналт, өгөгдлийн шинжилгээг автомат процессийн оролцоотойгоор хийх боломж НХҮГ, НДЕГ болон яамны түвшинд байхгүйгээс хугацаат тайланг үйлдэх, эрх бүхий байгууллагуудаас халамжийн болон даатгалын асуудлаар ирүүлэх асуулгуудад хариу өгөх зэрэгт ихээхэн гар ажилбар шаардагддаг. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, backup буюу хамгааллыг бүрдүүлэх процесс энэхүү хоёр системийн хувьд хангалтгүй бөгөөд өнөөдөр хэрэглээнд байгаа бүх програм албан ёсны зөвшөөрөлгүйгээр ашиглагдаж байна. Open source буюу үнэгүйгээр авч ашиглаж болдог програм хангамжийг боломжтой бүх нөхцөлд хэрэглэх нь зүйтэй. НХҮГ, НДЕГ аль аль нь хангалттай гэхээр хүний нөөцтэй хэдий ч мэдээллийн технологийн чиглэлээр томоохон өөрчлөлтүүд хийгдэх учир чадавхийг дахин үнэлэх шаардлага бодитойгоор тавигдаж байна. Яам агентлагийн төдийгүй аймаг, дүүрэг, сумын түвшинд нэмэлт техник хангамж (компьютерууд, серверууд, тоон мэдээллийн агуулахууд) шаардлагатай, гэхдээ энэ асуудлыг засвар үйлчилгээ хийх, элэгдэл хорогдол тооцох, төхөөрөмжийг орлуулан солих зэргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв мөнгөний асуудалтай хамтад нь шийдэх шаардлагатай. Өнөөдөр тус улсын нийт сумын тал хувь нь интернет сүлжээнд холбогдоод байгаа бөгөөд алслагдмал сумуудыг ч интернет сүлжээнд хамруулах ажлыг засгийн газар хувийн сектортай хамтран шийдвэрлэж байна. НДЕГ-ын хувьд зурвасын өргөн одоогоор хангалттай байгаа хэдий ч ирээдүйд буй болох хэрэгцээг харгалзан үзэж хүчин чадлын дахин үнэлгээг хийх шаардлагатай. Үйл ажиллагааны гарын авлага Н5/ВР-ын 4-р зүйлд заасан шалгуур нөхцлийг энэхүү нэмэлт санхүүжилт хангаж байна. Үүнд: (i) АХБ-ны зүгээс 2013 оны 2-р сард анхдагч төслийн хэрэгжилтийг үнэлсэн бөгөөд төслийн арга аргачлалд оруулахаар төлөвлөсөн өөрчлөлт байхгүй. Тиймээс анхдагч төслийг техникийн хувьд хэрэгжих боломжтой, эдийн засгийн хувьд үр ашигтай, санхүүгийн хувьд үндэслэлтэй хэмээн үзнэ, (ii) Засгийн газрын зүгээс анхдагч төсөлд өндөр ач холбогдол өгч үргэлжлүүлэхэд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг хүссэн. Энэхүү нэмэлт санхүүжилт нь Засгийн газрын 2012- 2016 оны мөрийн хөтөлбөрт багтсан иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэлгүйгээр хүргүүлэх бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй бөгөөд Засгийн газар хүсэлт гаргасан явдал нь ач холбогдолтойг харуулж байна; (iii) шинэчлэн тодорхойлсон төслийн үр дүнд анхдагч төслийн үр дүнд гарсан

амжилт улам батжиж нийгмийн хамгааллын үйлчилгээ улам сайжран нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжинө.

■ Хөгжлийн нөлөөлөл

Нийгмийн тэгш байдал дээшлэх, ядуурал буурах, нийгмийн эрсдлийг бууруулах болон урьдчилан сэргийлэх чадавхи дээшлэх, хүнсний баталгаат байдал сайжрах.

■ Төслийн үр дүн

Үр дүнгийн тодорхойлолт

Үр дүнд хүрэх явц

Бодлого, тогтолцоо, мэдээллийн технологийг – бэхжүүлэх замаар нийгмийн халамж болон нийгмийн даатгалын үйлчилгээг илүү түргэн шуурхай, ил тодоор хүргүүлэх (үүнд хүнсний хэрэглээг дэмжих хөтөлбөрийн үр дүн багтана)

■ Үр дүн ба хэрэгжилтийн явц

Төслийн үр дүнгийн тодорхойлолт

Хэрэгжилтийн явцын төлөв (Үр дүн, үйл ажиллагаа ба асуудлууд)

Бүрэлдэхүүн хэсэг 1: Хүнсийг талоноор олгох зорилтот хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх 1.1 хүнсийг талоноор олгох төслийг зорилтот болгох шинлэг арга аргачлалыг 2009 оны 12-р сард багтаан турших 1.2. 2009 оны 6-р сард багтаан хүнсний талоньг иргэдэд түгээх механизмыг бий болгох Бүрэлдэхүүн хэсэг 2: Хүнсийг талоноор олгох хөтөлбөрийн хүрээнд чадавхийг бэхжүүлэх, мэдээлэл харилцааны стратегийг боловсруулах 2.1. Үндэсний болон орон нутгийн оролцогч талуудын чадавхийг дээшлүүлж, институцын тогтолцоог бэхжүүлэх арга замыг 2010 оны 1-р сард багтаан боловсруулах, хэрэгжүүлэх 2.2. Хүнсийг талоноор олгох хөтөлбөрийг ил тод байдлаар хэрэгжүүлэх баталгаа мэдээлэл харилцааны стратегийг 2009 оны 12-р сард багтаан боловсруулах, хэрэгжүүлэх. Бүрэлдэхүүн хэсэг 3: Нийгмийн халамжийн стратеги, тогтолцоог бэхжүүлэх 3.1. Хүнсний хямралыг үр дүнтэй даван туулах хариу арга хэмжээний төслийг 2010 онд багтаан боловсруулах 3.2. Нийгмийн халамж, даатгалын үйлчилгээг илүү түргэн шуурхай, ил тод болгох мэдээллийн технологийн процесс, системүүдийг нэвтрүүлэх 3.3. 2017 онд багтаан нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх,

Зээлийн гэрээнд талууд 2014 оны 2-р сарын 6-нд гарын үсэг зурж батласан. Гэрээг УИХ-ын хаврын чуулганаар (2014 оны 4-7 сар) соёрхон батлаж улмаар зээл хүлээгдэлгүйгээр олгогдоно гэсэн хүлээлттэй байна.

нийгмийн хамгааллыг бэхжүүлэх үйл явцыг хэрэгжүүлж дуусгах 3.4 Нийгмийн шокийн эсрэг эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээний тогтолцоог 2011 оны 10-р сард багтаан буй болгох

Хөгжлийн төслүүдийн статус

Бодит өөрчлөлт

–

–

■ Бизнесийн боломж

Жагсаалтад анх оруулсан огноо –

Зөвлөх үйлчилгээ

–

Худалдан авах ажиллагаа

–

Худалдан авах ажиллагаа болон зөвлөх сонгон шалгаруулах мэдэгдэл

<http://www.adb.org/projects/42322-023/business-opportunities>

■ Цаглабар

Концепцийг батлах 2013 оны 6-р сарын 21

Судалгаа хийх 2013 оны 6-р сарын 24-нөөс 2013 оны 7-р сарын 06

Удирдлагаар хэлэлцүүлэх уулзалт 2013 оны 9 дүгээр сарын 11

Батлах 2013 оны 12 дугаар сарын 10

Хянан магадлах айлчлал –

■ Онцлох цаглабар

Батламжийн дугаар.	Батлагдсан	Гарын үсэг зурсан	Хүчин төгөлдөр болсон	Хаагдах		
				Анхдагч	Шинэчилсэн	Бодит
Зээл 3086	2013 оны 1—р сарын 10	2014 оны 2-р сарын 6	–	2017 оны 11-р сарын 30	–	–
–	–	–	–	–	–	–

■ Холбоо барих ба мэдээллийг шинэчлэхэд

АХБ-ны хариуцах ажилтан	Клод Бодарт (cbodart@adb.org)
АХБ-ны хариуцах газар	Зүүн Азийн газар
АХБ-ны хариуцах хэлтэс	Хот ба нийгмийн салбарын хэлтэс, ЗАГ
Хэрэгжүүлэгч байгууллага	–

■ Холбоосууд

Төслийн цахим хуудас	http://www.adb.org/projects/42322-023/main
Төслийн баримт бичгүүдийн жагсаалт	http://www.adb.org/projects/42322-023/documents
